



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-6
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	4-5
<i>2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	5-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 17-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, М.Оюунчимэг, С.Чинзориг, Т.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, Даргын зөвлөх Ү.Амарбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, Даргын зөвлөх Ү.Амарбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан” танхим 15 цаг 18 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны ирц бүрдлээ.

2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Байнгын хорооны хуралдааныг эхэлснийг нээснийг мэдэгдье ээ. Хуулийн тайлбарыг уншъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.2-т Байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний олонх хүрэлцэн ирсэн бол түүнийг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр ирцтэй гэж үзнэ гэж заасан байгаа. Энэ хуулийн тайлбарыг та бүхэнд танилцуулъя.

Ингээд ирц танилцуулъя. Ц.Цэрэнпунцаг гишүүн өвчтэй, Д.Батлут гишүүн ирсэн, Б.Баттөмөр гишүүн ирсэн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Ж.Ганбаатар гишүүн ирсэн, Х.Ганхуяг гишүүн ирсэн, Т.Доржханд гишүүн ирсэн байна. Ч.Ундрал гишүүн ирсэн, Ч.Хүрэлбаатар гишүүн ирсэн, Ц.Цогтгэрэл гишүүн ирсэн, Б.Энхбаяр гишүүд хуралдаанд өнөөдөр ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх,

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Энд бас хуулийн тайлбарыг уншиж танилцуулах ёстой.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 11.3.6-д хэлэлцүүлгийг тасралтгүй явуулна. Төслийг чуулган нэгэнт хэлэлцэж эхэлсэн бол эцсийн шийдвэр гартал Улсын Их Хурал өөр асуудал хэлэлцэхгүй гэж, 11.5-д энэ хуулийн 11.3.6 дахь заалт нь хэлэлцүүлгийн үе шат хооронд зохион байгуулалтын болон нэг удаагийн хэм хэмжээний бус шинжтэй хойшлуулигүй түүнчлэн хуулиар Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг шийдвэрлэхэд хамаарахгүй гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж санал дүгнэлтээ гаргана гэж, 49.7-д Байнгын хорооны хороод санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ гэж тус тус заасан.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаарх асуудлыг хэлэлцье.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барсүрэнгийн

Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Үүрцайхын Амарбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Дагва-Очирын Бумдарь МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Чойжилсүрэнгийн Ариунхур Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлах зөвлөх гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хэлэлцүүлгээ эхэлье. Хэлэлцүүлэг эхлэхийн өмнө холбогдох хуулийн заалтыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1 Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал дүгнэлтийг гаргана.

2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан.

Хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Санал ирээгүй байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн тухай 2 дахь хэлэлцүүлэгт оруулах талаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүд анхааралтай байгаарай санал хураалт явуулъя.

Саналын томьёоллыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт 80 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт 80 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна.

Асуулт асуух гишүүд алга байна. Санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна санал ирээгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ

өгнө үү? Асуулт байхгүй байна. Санал ирээгүй байна. Асуулт асуух гишүүд алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын

хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулна. Хуралдаанд идэвхтэй оролцсонд баярлалаа. Энэ өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

13:27

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА